

1948 оны 10-р сарын 8-ны өдөр.

Ардын Сайд нарын Зөвлөл ба Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны тэргүүлэгчдийн 68/80 дугаар
хурлын Т О Г Т О О Д .

Санхүүгийн аппаратаг бэхжүүлэх ба түүний
ажиллах бололцоог дээшлүүлэх талаар авах
арга хэмжээнүүдийн тухай.

Ардын Сайд нарын Зөвлөл, Монгол Ардын Хувьсгалт Намын
Төв Хорооноос яэмдэглэх нь:

Сангийн яам ба түүний орон нутгийн байгууллагуудын
зохион байгуулалтын орон тоо нь улсын төсвийг бэхжүү-
лэх ба улс ардын аж ахуйн бүх салаа мөчрүүдийн санхүү-
гийн ажил явуулагыг сайжруулах гэсэн сангийн яам болон
түүний орон нутгийн байгууллагуудын өмнө зогсож байгаа
зорилгуудыг биелүүлэх явдлыг хангаж чадахгүй байна.

Улсын төсөв, эдийн засгийн ажил нь Сангийн Намны хэм-
хээн дээр хангалтгүй явагдаж байгаа бөгөөд улсын төс-
вөөр са хүүшигддэг албан байгууллагуудын аж ахуйн ажил
явуулагыг судлах ба төсөвлөсөн хөрөнгийг хэрхэн зө-
вөөр чиглүүлж ашиглан хэрэглэж байгааг хянах ажил су-
лаар явагдаж байна.

Улсын төсвийг бэхжүүлэх явдалд асар их ач холбогдол
бүхий орлогын зүйлүүдийг хүчтэй болгох ба шинэ орлогууд-
ыг ирж олох талаар санхүүгийн аппарат нь сулаар ажиллаж
байгаа зэргийн дутагдлуудыг арилгах ба санхүүгийн аппа-
ратыг бэхжүүлэх, түүний ажиллах бололцоог сайжруулахын
тулд Ардын Сайд нарын Зөвлөл, Монгол Ардын Хувьсгалт Намын
Төв Хорооны хавсарсан хурлаас ТОГТООХ нь:

Нэг. 1941 оны 9 сарын 19-ны өдөр хуралдсан Ардын Сайд нарын Зөвлөлийн 48 дугаар хурлаар батлагдсан Сангийн Яамны дүрмийн 10 ба 12-р зүйлүүдийг өөрчилж Сангийн Яаманд дор дурьдсан зохион байгуулалтын өөрчлөлтийг оруулан батлах үүнд:

- 1/Захиргаа
- 2/Төсөвлөсөн дансын хэлтэс
- 3/Албан татварын хэлтэс
- 4/Улсын орлогын хэлтэс
- 5/Төв нягтлан бодохын анги
- 6/Хянан байцаах газар
- 7/Аж ахуйн хэлтэс.

Хоёр. Сангийн яамны төв аппаратын орон тоог 43 оноос 65 хүртэл Улаанбаатар хотын санхүүгийн хэлтсийн орон тоог 8-аас 13 хүртэл, мөн Сүхбаатар, Чойбалсан хотын санхүүгийн аппаратын орон тоог 2-3 хүртэл тус тус нэмэгдүүлсүгэй.

Гурав. Төв ба орон нутгийн санхүүгийн аппаратын орон тоог нэгэн сарын дотор нөхөж авахыг Сангийн Яамны сайд БЯМБАА-д даалгасугай.

Дөрөв. Сангийн яамны орлогын хэлтсийн ажилчдын хоорондын үүрэг ажлыг улсын орлогот орох орлогуудын чанар мөн төсөвлөсөн дансын хэлтэс хийжээд шалган байцаах газрын ажилчдын ажил үүргийг улсын төсвөөс санхүүжүүлэгдээ байгаа ба аж ахуйн тооцоо бүхий улс ардын аж ахуйн салаа мөчрүүдээр хувиарлахыг Сангийн яамны сайд нөхөр Бямбаад даалгасугай.

Тав. Сангийн яамны төсөвлөсөн дансны хэлтэс хийгээд шалган байцаах газарт цэрцг дотоод яамны төсвийн талаар тусгай ажиллуулахаар тус бүр санхүүгийн мэрэгжил бүхий 2 ажилчдыг сангийн яамны мэдэлд гаргаж өхийг орлогч ханжин Лхавагсүрэн, Дотоод Яамны сайд ШАГДАРЖАВ нарт даалгасугай.

Зургаа. Санхүүгийн системийн ажилчдын цалинг батлах

үүнд:

Төвийн аппарат.

1/Газрын ба хэлтсийн дарга	340-400 төгрөг хүртэл
2/Газрын хэлтсүүдийн орлогч дарга нар	300-375 -"-
3/Ахлагч зааварлагч нар	340-375 -"-
4/Байцаагч нар	300-330 -"-
5/Ахлагч байцаагч нар	350-3290 -"-
6/Зааварлагч нар	300-340 -"-
7/Ерөнхий нягтлан бодох	450-500 -"-
8/Ахлагч нягтлан бодох нар	380-350 -"-
9/Нягтлан бодох нар	295-320 -"-
10/Дансны ахлагч бичээч	250-275 -"-
11/Дансны бичээч	220-245 -"-
12/Орчуулагч нар	300-365 -"-
13/Нарийн бичгийн дарга нар	240-275 -"-
14/Машины бичээч нар	225-450 -"-
15/Комендат нар	225-250 -"-
16/Бичиг хэрэг хөтлөгч	225-250 -"-
17/Гарамийн дарга	340-375 -"-
18/Жолооч нар	285-320 -"-
19/Зарлага нар	175 төгрөг
20/Цэвэрлэгч	185 -"-

21/ЦЭВЭРЛЭГЧ 185 төгрөг

22/Морин тэрэгний ажилчин 210 -"-

2/Улаанбаатар хотын санхүүгийн хэлтсийн ажилчид.

- 1/Хэлтсийн дарга 340-аас 400 төг хүртэл
- 2/Хэлтсийн даргын туслах 320-аас 375 -"-
- 3/Ахлагч байцаагч нар 310-аас 330 -"-
- 4/Байцаагч нар 280-аас 300 -"-
- 5/Шалгагч нар 280-аас 300 -"-
- 6/Ерөнхий нягтлан бодох 320-350 -"-
- 7/Туслах нягтлан бодох 275-аас 300 -"-
- 8/Дансны ахлагч бичээч нар 240- 270 -"-
- 9/Дансны бичээч нар 220-240 -"-

3/Аймаг, хотын санхүүгийн хэлтэсүүд.

- 1/Хэлтсийн дарга нар 245 -аас 275 төгрөг
- 2/Байцаагч нар 185-аас 235 -"-
- 3/Нягтлан бодох нар 225-250 -"-

Эдгээр болох бөгөөд энэхүү тогтоосон цалин хөлсийг 1943 оны 10 сарын нэгнээс эхлэн явуулбал зохих бөгөөд үүнийг олгохдоо тухайн ажилчдын дадлага мэрэгжил бүхий болон гүйцэтгэж буй ажлын хир хэмжээг ба чанарын байдлыг харгалзан Сангийн Яамны Саядын тушаалсаар олгож байвал зохно.

Долоо.Сайд нарын Зөвлөлийн хурал дээр хэлэлцэх санхүүгийн асуудлуудыг боловсруулан бэлтгэж байхыг тулд ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайдын дэргэд ажиллаж байх байцаагч,консултантын орон тоог байгуулсугай.

5.

НАЙМ.

Намын Төв Хороо Засгийн газрын зөвлөөрөлгүйгээр тусгай бэлтгэл сургууль бүхий бөгөөд тус улсын санхүүгийн байгууллагуудад ажиллаж буй ажилчдыг өөр газар шилжүүлэх явдлыг шууд хоргилсугай.

Ерөнхий сайд, улсын шалгарсан баатар маршал

ЧОЙБАЛСАН.

Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга

ЦЭДЭНБАЛ.

/эр материалаас цохив Долгор/

1963.2.15.